



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 27 өдөр

Дугаар А/300

Сүхбаатар сум

Газар эзэмших эрхийг баталгаажуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3."г", Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 25 дугаар зүйлийн 25.1, 28 дугаар зүйлийн 28.1.3, 43 дугаар зүйлийн 43.1, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, аймгийн Засаг даргын 2011 оны "Аймгийн төвийн инженерийн шугам сүлжээ бүхий бүсийн хилийг шинэчлэн тогтоох тухай" А/39 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Энэхүү захирамжийн хавсралтад дурдсан Сүхбаатар сумын нэр бүхий 2 иргэнд 660м² газрыг гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар газрын эзэмших эрхийг анх олгосон хугацаагаар баталгаажуулсугай.

2. Туузан метрээр хэмжилт хийгдэн анх олгогдсон дээрх газарт кадастрын зураглал хийн холбогдох баримтуудыг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн дундын мэдээллийн санд илгээж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож эрхийг нь баталгаажуулан, нэгж талбарын хувийн хэрэгт баяжилт хийж, газар эзэмшигчийн улсын бүртгэлд бүртгэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Б.Саруултөгс/-д даалгасугай.


3. Эзэмшил газрынхаа арваас доошгүй хувьд ногоон байгууламж бүрдүүлэн, тохижуулж, хамгаалах, газар эзэмших гэрээ байгуулан улсын бүртгэлд бүртгүүлэхийг дээрх нэр бүхий иргэдэд үүрэг болгосугай.

4. Эзэмшилд олгогдсон газрын ашиглалт, хамгаалалтын байдалд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын түр орлон гүйцэтгэгч /Баттүвшин/-д хариуцуулсугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дээрх газар эзэмшигчдийн эзэмшилд олгосон Сүхбаатар сумын Засаг даргын 2009 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 141, 2008 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 211 тоот шийдвэрийн холбогдох заалт, дугаар бүхий газар эзэмших эрхийн гэрчилгээ, гэрээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ОРГИЛ



Сэлэнгэ аймгийн Засаг даргын
2020 оны 10 сарын 17-ны өдрийн
А/300 тоот захирамжийн хавсралт

№	Газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж байгууллага		Нэгж талбарын дугаар	Эзэмшүүлэх газрын байршил	Газрын хэмжээ /м2/	Газрын зориулалт	Газар эзэмших хугацаа	Хүчингүй болсон гэрчилгээ, гэрээний дугаар /тайлбар/
	Иргэн, аж ахуйн байгууллагын нэр	Регистр, улсын бүртгэлийн дугаар						
1	Боржигон Лхагвасүрэн Баясгалан	МВ77110514	4308012309	Сүхбаатар сумын Орхон 6-р баг Г.Төмөрбаатар 2-р гудамж 205 тоот	300	Гэр орон сууцны хашааны газар	2009 оноос 15 жил	Сүхбаатар сумын Засаг даргын 2009-06-09-ны өдрийн 141 тоот захирамжийн 1-р хавсралтын Л.Баясгалан /МВ77110514/-д холбогдох хэсэг, 264897 дугаартай гэрчилгээ, 00157 тоот гэрээ
2	Боржигон Лувсангэндэн Энхтунгалаг	Мь79090903	4308012310	Сүхбаатар сумын Орхон 6-р баг Г.Төмөрбаатар 2-р гудамж 205 тоот	360	Гэр орон сууцны хашааны газар	2008 оноос 40 жил	Сүхбаатар сумын Засаг даргын 2008-05-22-ны өдрийн 211 тоот захирамж П.Энхтунгалаг /Мь79090903/-д холбогдох 306978 дугаартай гэрчилгээ, 00270 тоот гэрээ
Нийт					660			